

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, тусгай зөвшөөрөл

8 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн бүртгэл

8.1. Усан замын тээврийн хэрэгслийг энэ хуулийн 14.3-д заасан журмын дагуу бүртгэнэ.

8.2. Усан замын тээврийн хэрэгслийг эзэмшигч нь усан тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн гэрчилгээ авна. Гэрчилгээнд тээврийн хэрэгслийн марк, нэр, дугаар, үйлдвэрлэгдсэн он, эзэмшигчийн нэр зэргийг тэмдэглэсэн байна.

8.3. Усан замын тээврийн хэрэгслийн дугаарыг усан тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.

8.4. Усан замын тээврийн хэрэгслийн нэр буюу дугаарыг тээврийн хэрэгслийн үзэгдэх хэсэгт дэвсгэр өнгөнөөс тодоор ялгагдах өнгөөр тэмдэглэнэ.

8.5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн усан онгоцон дээр Монгол Улсын Төрийн далбааг мандуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналт

14 дүгээр зүйл. Техникийн хяналт, тооллого

14.3. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг усан замын тээврийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТЕХНИКИЙН БОЛОН ЭКОЛОГИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ, ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

3. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох

3.1. Усан замын тээврийн хэрэгслийг 16 буюу түүнээс дээш насанд хүрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаягаар бүртгэж, орон нутгийн харъяаллын дагуу ялгах тэмдэг бүхий улсын дугаар, гэрчилгээ олгоно.

3.2. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн картыг нууцлалын шаардлагыг хангаж хэвлүүлэн, бүртгэж хадгална. Гэрчилгээг, энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварын дагуу олгоно.

3.3. Бага оврын усан онгоц, завь, катер нь хувийн хэрэгтэй байх ба хувийн хэргийг журмын 3 дугаар хавсралтаар баталсан бага оврын усан онгоц, завь, катерын хувийн хэргийн загварын дагуу холбогдох байгууллагаас олгоно.

3.4. Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ.

Үүнд:

3.4.1. Иргэн бол иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ, хүсэлт;

3.4.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, бусад дагалдах баримт бичиг;

3.4.3. Импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлт хийснийг нотлох баримт бичиг;

3.4.4. Усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүнийг нотолсон баримт бичиг;

3.4.5. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн акт, дүгнэлт;

3.4.6. Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох албан татварыг төлсөн баримт.

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

Гурав. Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

3.4.5. дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар, гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

Арван найм. Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

18.1.9. усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр:

18.1.9.а. дунд оврын хөлөг онгоцонд 350 000 төгрөг;

18.1.9.б. бага оврын усан онгоцонд 200 000 төгрөг;


18.1.9.в. жижиг оврын моторт завинд 100 000 төгрөг.

Зам, тээврийн сайд, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын хамтарсан 2014. оны 138/А-208 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар, түүнийг тэмдэглэх хэмжээ, байршил

1. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар нь харъяалагдах улс, тухайн орон нутгийг заасан гурван үсэг, усан замын тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн дарааллаар нь олгосон цифрээс бүрдэнэ. Цифр нь 01-ээс эхлэх ба цаашид бүртгэгдсэн усан замын тээврийн хэрэгслийн тооноос хамаарч аравт, зуут, мянгатын оронд шилжих маягаар дугаарлагдана. Жишээ нь: М 01ХӨ - гэсэн улсын дугаарын М үсэг нь Монгол Улс, 01-хамгийн эхэнд бүртгүүлсэн усан замын тээврийн хэрэгслийн дугаар, ХӨ- Хөвсгөл аймаг.

Өмчлөгч /эзэмшигч/ нь улсын дугаарын зэрэгцээ усан замын тээврийн хэрэгсэлдээ нэр авах хүсэлт гаргасан бол, түүний санал болгосон нэрийг олгоно.



2. Усан замын тээврийн хэрэгсэлд олгосон улсын дугаарыг тухайн тээврийн хэрэгслийн хамрын хоёр хажуу талд, түүний хошуун талаас, их биеийн уртын $\frac{1}{4}$ -тэй тэнцэх хэмжээний зайд, их биеийн дэвсгэр өнгөнөөс тод ялгарах өнгийн будгаар буюу зориулалтын наалт нааж тэмдэглэнэ.

Улсын дугаарын үсэг, тооны өндөр 150 мм-ээс багагүй, өргөн нь 100 мм, зураасны өргөн 15-20 мм байх ба дармал том үсгээр бичнэ. Үсгүүд нь тоонуудаасаа тухайн үсгийн буюу тооны өргөнтэй тэнцүү хэмжээгээр тусгаарлагдсан байна. Жишээ нь: **М 01 ХӨ**

Усан замын тээврийн хэрэгслийн зохион бүтээгдсэн онцлогоос хамаарч дээр дурдсан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд улсын дугаарын хэмжээ 7.6 см-ээс багагүй өндөртэй байх ба дугаар тэмдэглэх байршлыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагчаас зөвлөгөө авч тодорхойлно.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Усан замын тээврийн тухай хуулийн 8, 9-р зүйлийн дагуу техникийн шаардлага, шаардлагатай бичиг баримт, гэрчилгээтэй байна.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, тусгай зөвшөөрөл

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

9.1. Усан замын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэнд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгоно.

9.2. Тусгай зөвшөөрөл авахад аж ахуйн нэгж, иргэн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

9.2.1. ажил, үйлчилгээг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, усан замын тээврийн хэрэгслийн бичиг баримтын бүрдэл, усан замын тогтоосон чиглэл, аюулгүй ажиллагааны шаардлага;

9.2.2. тухайн ажил, үйлчилгээнд мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл.

9.3. Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулж ажиллана.

9.4. Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэхээр хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд уг ажил, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг харгалзан сонирхогчдыг сонгон шалгаруулах замаар тусгай зөвшөөрөл олгож болно.

2. Зам, тээврийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 142 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

ХОЁР. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага

2.1. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2. Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 23 дугаар тушаалаар батлагдсан “Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм”,

2.3. Зам, тээврийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан 2014 оны 138/А-208 дугаар тушаалаар батлагдсан “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн бүртгэлийн гэрчилгээ авсан байх ба техникийн болон экологийн хяналтын үзлэг хийлгүүлэн тэнцсэн үнэлгээ авч тэмдэглэгээ хийлгэсэн байх;

2.4. Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 45 дугаар тушаалаар батлагдсан “Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ын шаардлагууд;

2.5. Усан замын тээврийн хэрэгслийн жолоодогч нь Далайн захиргаанаас олгосон усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэйг гэрчилсэн мэргэжлийн үнэмлэх болон холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж гэрчилгээ болон түүнтэй адилтгах баримт бичиг авсан байх,

ГУРАВ. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг

3.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь “Усан замын тээврийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгааг нотолсон бичиг баримт;

3.3. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /үйлчилгээ эрхлэх нутаг дэвсгэр, маршрут, үйлчилгээний төрөл, хугацаа/;

3.4. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.5. Усан замын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.6. Усан замын тээврийн хэрэгслийн багийн бүрэлдэхүүнд усан спорт сургалтын төвийн сургалтанд хамрагдсан усчин-аврагч гэдгийг нотолсон баримт бичиг;

3.7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

(Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтын
18.1.9.в. заасныг баримтлан тэмдэгтийн хураамж ногдуулна.)

Тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөх данс

Байгууллагын нэр: **Зам, тээврийн яам**

Банкны нэр: **Улаанбаатар банк**

Данс : **2600074943**

Гүйлгээний утга:....Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний тэмдэгтийн хураамж

Тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөх данс

Байгууллагын нэр: **Зам, тээврийн яам**

Банкны нэр: **Улаанбаатар банк**

Данс : **2600074943**

Гүйлгээний утга:... Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх, тусгай зөвшөөрлийн
тэмдэгтийн хураамж

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА
Х.ЭНХБААТАР ТАНАА

Хүсэлт гаргах нь

/Овог, Нэр/ миний бие

.....
.....
/ завь катерын үйлдвэрлэгдсэн он, үлс, марк, суудлын тоо, моторын хүчин чадал, марк,
арлын дугаар/ Монгол Улсад оруулж ирсэн огноо, худалдан авсан огноо/
..... /аймаг, сум, гол, мөрөн, нуур/-нд
ашиглах тул усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгож өгөхийг хүсье.

Хүсэлт гаргасан

...../.....гарын үсэг.../

/Хаяг, холбогдох утас/

/..... он ... сар ... өдөр/